

2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД

Шинжээч сонгон шалгаруулах урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх”-ын аудитын хүрээнд “Хятад хэлний орчуулагчийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх” шинжээч сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг саналаа ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын дагуу хэрэгжих бөгөөд сонгон шалгаруулалтад оролцогч этгээдийн санал нь санал хүлээн авахаар төвлөсөн өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Шинжээчийг сонгох урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй. Үүнд:

- Ажлын даалгавар
- Саналын баримт бичиг

Шинжээч нь **ҮАГ-АД/22-039** дүгээр ажлын даалгаварт заасан хятад хэлний аман болон бичгийн орчуулга хийх, аудитад шаардлагатай мэдээллийг цуглуулах, нэгтгэх чиг үүргийг аудитын багтай хамтран хэрэгжүүлж, дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Аудитын хүрээнд газрын тосны салбарын техникийн нэр томьёо, агуулга, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон санхүүгийн тайлан, өртөг нөхөх зардлын тайланг үнэн зөв, нягт нямбай орчуулах;
- Аман яриаг шууд дагаж орчуулах, ярианы агуулга, утга санаа, хэв маягийг аль болох зөв хадгалж, бүрэн гүйцэд орчуулах, түүнийг баримтжуулах;
- Бичгийн орчуулгын баримт материалыг нягтлан уншиж, үнэн зөв орчуулах, ажлын баримт үйлдэх, аудитын явцад архивын нэгж болгон цэгцлэх;
- Аудитын талбарт болон албан томилолтоор ажиллах.

Аудитын хамрах хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 2020-2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, өртөг нөхөх зардлын тайлан, мэдээг хамруулж, холбогдох баримт бичгийг гэрээ байгуулан ажилласнаас 40 хоногийн хугацаанд багтаан аудитын багт хүлээлгэн өгнө.

Сонирхсон этгээд нь Ажлын даалгавар, “Шинжээч сонгох саналын баримт бичиг” бусад холбогдох мэдээллийг www.audit.mn цахим хаягаас болон ҮАГ-ын Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюушаас авч болно. Ажлын утас: 51-261745, гар утас: 88051068.

Саналыг файл хэлбэрээр info@audit.gov.mn, tsend-ayushn@audit.gov.mn цахим шуудангаар 2022 оны 12 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө ирүүлнэ үү. Захиалагчийн хаяг: Үндэсний аудитын газар-15160. Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.



(Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх) **АУДИТ**

ХЯТАД ХЭЛНИЙ ОРЧУУЛАГЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 11 дүгээр сарын
11-ны өдөр

Дугаар
22-039

Улаанбаатар
хот

Ажлын зорилго: Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын хүрээнд хятад хэлний аман болон бичгийн орчуулга хийх, аудитад шаардлагатай мэдээллийг цуглуулах, нэгтгэх чиг үүргийг аудитын багтай хамтран хэрэгжүүлэх.

Ажил гүйцэтгэх хугацаа: 2022.12.12-2023.01.30

Байршил: Үндэсний аудитын газар

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 17 дугаар зүйлийн 17.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газар (цаашид “захиалагч” гэх) Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2020-2021 оны батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийж баталгаажуулна.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

Шинжээч орчуулагч нь дараах ажлыг гүйцэтгэнэ.

- Аудитын хүрээнд газрын тосны салбарын техникийн нэр томьёо, агуулга, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон санхүүгийн тайлан, өртөг нөхөх зардлын тайланг үнэн зөв, нягт нямбай орчуулах;
- Аман яриаг шууд дагаж орчуулах, ярианы агуулга, утга санаа, хэв маягийг аль болох зөв хадгалж, бүрэн гүйцэд орчуулах, түүнийг баримтжуулах;
- Бичгийн орчуулгын баримт материалыг нягтлан уншиж, үнэн зөв орчуулах, ажлын баримт үйлдэх, аудитын явцад архивын нэгж болгон цэгцлэх;
- Аудитын талбарт болон албан томилолтоор ажиллах.

ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитын хамрах хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 2020-2021 онд батлагдсан

төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, өртөг нөхөх зардлын тайлан, мэдээг хамруулна.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Ажлын гүйцэтгэлээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Гэрээлэгчийн хятад хэл дээр үйлдсэн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, санхүүгийн тайлан, өртөг нөхөх зардлын тайланг монгол хэл рүү үнэн зөв орчуулснаар тухайн аудитыг хэвийн гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ.
- Аудитын явцад гэрээлэгч талтай харилцахад /ашиглалтын талбайд томилолтоор ажиллана/ хятад хэлний ярианы орчуулгыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэнэ.
- Шаардлагатай тохиолдолд тодруулга, нэмэлт баримт орчуулна.
- Ажлын даалгаварт заасан ажил үүргийг ахлах аудитор, аудитын менежер, газрын захирал, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн өгсөн чиглэлийн дагуу тухай бүр чанартай, түргэн шуурхай гүйцэтгэж, ажлын тайлан бэлтгэсэн байна.
- Аудитыг хараат бусаар гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ.

ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд ажиллах иргэн, хуулийн этгээд нь /цаашид “шинжээч” гэх/ аман болон бичгийн орчуулга хийх, аудитад шаардлагатай мэдээллийг цуглуулах, нэгтгэх чиг үүргийг аудитын багтай хамтран хэрэгжүүлнэ.

Тус ажлыг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэхээр шалгарсан шинжээч орчуулагч нь захиалагч Үндэсний аудитын газрыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, аудитын багтай уулзалт, ярилцлага хийж, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Үе шатны ажлын явцад бий болсон шийдвэрлэх боломжгүй асуудлыг тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, хамтарч ажиллана.

ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Шинжээч орчуулагч нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хүн, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээч орчуулагчид дараах боловсролын үндсэн мэргэжил, зэрэг, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Орчуулгын үйл ажиллагаа явуулах эрхтэй аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй байх;
- Татвар, нийгмийн даатгалын байгууллагад өргүй байх;
- Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Мэргэжлийн чиглэлээр магистр, эсхүл түүнээс дээш дээд боловсролын зэрэгтэй байх;
- Хятад хэлний аман болон бичгийн орчуулга хийх бүрэн чадвартай;
- Хятад хэлний HSK-ийн 6-аас дээш зэрэгтэй;
- Тухайн мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан байх;
- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй бүтээл орчуулсан туршлагатай байх.

Ажиллах хүчний шаардлага:

- Хятад хэлний багш-орчуулагч мэргэжилтэй;
- Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан;
- Хятад хэлний аман болон бичгийн орчуулга хийх бүрэн чадвартай;
- Хятад хэлний HSK-ийн 5-аас дээш зэрэгтэй;
- Англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно
- Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай

- Багаар ажиллах, ачаалал даах чадвартай байх;
- Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан бол давуу тал болно.

Баг, хувь хүний хувьд:

- Багийн ахлагч нь хуулийн этгээдийн багийн ахлагчид тавигдсан шаардлагатай ижил шаардлагыг хангасан байх;
- Хятад хэлний багш-орчуулагч мэргэжилтэй;
- Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан;
- Хятад хэлний аман болон бичгийн орчуулга хийх бүрэн чадвартай;
- Хятад хэлний HSK-ийн 5-аас дээш зэрэгтэй;
- Англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно

Дээрх ажлын даалгаврын 6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн баталгаажсан хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим хаягаар ирүүлнэ.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Шинжээч орчуулагчийн ажлын хөлсийг харилцан тохиролцож, гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.


Хянасан:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ


АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ОТГОНБАЯР

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Б.АНХБААТАР

Ц.БАТСҮХ

Ц.ЦЭРЭННАМЖИЛ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



Огноо: 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

“ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР
ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “ДОНШЕН ГАЗРЫН ТОС
(МОНГОЛ)” ХХК-ИЙН 2020-2021 ОНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСВИЙН
ДАГУУ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ
НӨХСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ,
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ
ХИЙХ”-ЫН АУДИТЫН ХҮРЭЭНД
”ХЯТАД ХЭЛНИЙ ОРЧУУЛАГЧИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ”
ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАРИМТ БИЧИГ

УЛААНБААТАР ХОТ

2022 он

БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

- МАЯГТ 1-САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ
- МАЯГТ 2-ОРОЛЦОХ ХҮСЭЛТ
- МАЯГТ 3-ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 4-САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ ХҮСНЭГТ
- МАЯГТ 5-АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- МАЯГТ 6-БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ
- МАЯГТ 7-АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 8-ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 9-ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 10-ШИНЖЭЭЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (СӨХ)

№	Ерөнхий зүйл
1	Захиалагч нь: [Захиалагч нь: Үндэсний аудитын газар 15160. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.]
2	<p>Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж:</p> <p>Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй шинжээчийн баг, хуулийн этгээд нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба тус газрын Аудитын гуравдугаар газрын аудитын багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.</p> <p>Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.</p> <p>Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.</p>
3	Шинжээчийн үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай эсэх: “гүй”
4	<p>Санал хүлээн авах хугацаанаас 2 хоногийн өмнө албан бичгээр ирсэн тодруулгад хариу өгнө.</p> <p>Үндэсний аудитын газар. Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068.</p>
5	Саналыг Монгол хэлээр ирүүлнэ.
6	Хураангуй жагсаалтад орсон шинжээч эсхүл хуулийн этгээд мөн жагсаалтад орсон бусад компанитай хамтран ажиллаж болно: “хамааралгүй”
7	Шинжээчийн ажил үйлчилгээ ажлын даалгаварт тусгасан өдөрт багтаан гүйцэтгэнэ.
8	<p><u>Гүйцэтгэх ажлын үнийн санал</u></p> <p>Гүйцэтгүүлэх ажлын төсөвт өртөг: 11 520 000 /арван нэгэн сая таван зуун хорин мянган/ төгрөг байна.</p> <p>Шинжээчийн ажлыг гүйцэтгэх гэж буй зөвлөх нь ҮНЭ-ийг санал болгохдоо ажлын даалгаварт тусгагдсан ажилбар тус бүрийг тооцоолж, саналаа ирүүлэх шаардлагатай.</p> <p style="text-align: center;">ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ</p> <p>Шинжээч орчуулагч нь дараах ажлыг гүйцэтгэнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Аудитын хүрээнд газрын тосны салбарын техникийн нэр томьёо, агуулга, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон санхүүгийн тайлан, өртөг нөхөх зардлын тайланг үнэн зөв, нягт нямбай орчуулах; • Аман яриаг шууд дагаж орчуулах, ярианы агуулга, утга санаа, хэв маягийг аль болох зөв хадгалж, бүрэн гүйцэд орчуулах, түүнийг баримтжуулах; • Бичгийн орчуулгын баримт материалыг нягтлан уншиж, үнэн зөв орчуулах, ажлын баримт үйлдэх, аудитын явцад архивын нэгж болгон цэгцлэх; • Аудитын талбарт болон албан томилолтоор ажиллах.

АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитын хамрах хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй Петровича Дачин Тамсаг ХХК-ийн "Тосон Уул XIX", "Тамсаг XXI" талбайн 2020-2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, өртөг нөхөх зардлын тайлан, мэдээг хамруулна.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх, шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах үндсэн мэдээллийг баталгаажуулан ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2019, 2020, 2021 он/;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2020, 2021 оны жилийн эцсийн/.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ ирүүлэх /нотариатжуулсан/;

Мөн баримт бичигт хавсаргасан дараахь маягтаар саналаа илэрхийлсэн байна. Үүнд:

- Оролцох хүсэлтийн маягт. /Маягт 2/
- Оролцогчийн танилцуулга. /Маягт 3/
- Санал болгож буй мэргэжилтний намтар(CV). /Маягт 4/
- Ажил гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж. /Маягт 5/
- Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт. /Маягт 6/
- Ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга /Маягт 7/

Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага:

Шинжээч орчуулагч нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хүн, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээч орчуулагчид дараах боловсролын үндсэн мэргэжил, зэрэг, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Орчуулгын үйл ажиллагаа явуулах эрхтэй аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй байх;
- Татвар, нийгмийн даатгалын байгууллагад өргүй байх;
- Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - Мэргэжлийн чиглэлээр магистр, эсхүл түүнээс дээш дээд боловсролын зэрэгтэй байх;
 - Хятад хэлний аман болон бичгийн орчуулга хийх бүрэн чадвартай;
 - Хятад хэлний HSK-ийн 6-аас дээш зэрэгтэй;
 - Тухайн мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан байх;

	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй бүтээл орчуулсан туршлагатай байх. <p>Ажиллах хүчний шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Хятад хэлний багш-орчуулагч мэргэжилтэй; • Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан; • Хятад хэлний аман болон бичгийн орчуулга хийх бүрэн чадвартай; • Хятад хэлний HSK-ийн 5-аас дээш зэрэгтэй; • Англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно • Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай • Багаар ажиллах, ачаалал даах чадвартай байх; • Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан бол давуу тал болно. <p>Баг, хувь хүний хувьд:</p> <ul style="list-style-type: none"> • Багийн ахлагч нь хуулийн этгээдийн багийн ахлагчид тавигдсан шаардлагатай ижил шаардлагыг хангасан байх; • Хятад хэлний багш-орчуулагч мэргэжилтэй; • Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан; • Хятад хэлний аман болон бичгийн орчуулга хийх бүрэн чадвартай; • Хятад хэлний HSK-ийн 5-аас дээш зэрэгтэй; • Англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно <p>Дээрх ажлын даалгаврын 6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн баталгаажсан хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим хаягаар ирүүлнэ.</p> <p>Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.</p>
10	Шинжээчийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг Монгол хэлээр бэлтгэнэ.
11	Ажлын даалгаварт заасан бусад нэмэлт шаардлага. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.
12	Татвар [Гүйцэтгэгч, тэдгээрийн ажиллах хүчин нь холбогдох хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой. Иймд гэрээт ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварыг ажил олгогчийн зүгээс суутган тооцно. Гүйцэтгэгч нь гэрээнд заагдсан төлбөрийн хуваарийн дагуу цахим төлбөрийн баримтын системд төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн үед төлбөрийг шилжүүлнэ]:
13	Санал ирүүлэх тоо: эх хувь 1
14	Санал ирүүлэх хаяг: Цахимаар Үндэсний аудитын газар. Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068.
15	Саналыг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 17 цаг 30 минутаас өмнө ирүүлсэн байна.
16	(а) Төсөвт өртөг нь 50 сая ба түүнээс дээш өртөгтэй тул ажил гүйцэтгүүлэх тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа шаардана. (б) Гүйцэтгэлийн баталгааг зохих маягтын дагуу гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх бөгөөд гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгөн дүн нь санал болгосон үнэ буюу гэрээний үнийн дүнгийн 5 хувиас багагүй байна.

Гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

МАЯГТ 2

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г _____ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна. /төсвийн тооцоололыг хавсарган/

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

Холбоо барих утас: _____

ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1. Ерөнхий танилцуулга

.....

 (Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд нь дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. Нотлох баримтыг хавсарган ирүүлэх шаардлагатай.

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: _____

САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(СV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: _____

Байгууллагын нэр: _____

Мэргэжилтний нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.

[Мөн нотлох баримтыг материалд хавсарган ирүүлэх шаардлагатай]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ¹**

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- *Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ. Үүнд:*
-

№	Хийх ажилбар	Хэрэгжүүлэх хугацаа				Хариуцах ажилтан
		... хоног	... хоног		гэх мэт	

- *Ажил гүйцэтгэх аргачлалыг ажлын даалгаврыг үндэслэн дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.*

Баталгаажуулах

¹ Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.